

“АРИГ БАНК” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН

П.МӨНХ-ЭРДЭНИЙН 2022 ОНЫ 02 ДУГААР УЛИРЛЫН АЖЛЫН ТАЙЛАН

2022 оны 07 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021.04.05-ны өдрийн 5176 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1-т заасны дагуу 2022 оны 02 дугаар улирлын ажлын тайланг хүргүүлж байна. Тайлант хугацаанд Компанийн тухай хуулийн 59.4-д заасан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 1 (хойшлогдсон ээлжит хурал 1), ээлжит бус хурал 3 удаа, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 6 удаа хуульд заасны дагуу танхим, цахим хэлбэрээр хуралдаж, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрүүдийг гарган ажилласан байна. Үүнээс:

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус, хойшлогдсон хурлуудын талаар:

“Ариг банк” ХХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.9-д “Хувьцаа эзэмшигчдийн хурлыг ТУЗ-ийн дарга удирдана” гэж заасны дагуу тайлант хугацаанд хуралдсан хувьцаа эзэмшигчдийн 5 хурлыг даргалан ажилласан.

1. 2022-04-20: Компанийн тухай хуулийн 59.4-д зааснаар жилд 1 удаа зарлагдан хуралдах ээлжит хурлыг ТУЗ-ийн 2022.03.11-ний өдрийн Т/22/07 тоот тогтоолоор зарлан хуралдуулсныг даргалсан. Уг хуралд хувьцаа эзэмшигч “Дэм санхүүгийн нэгдэл” ХХК-ийн төлөөлөл хуралд ирээгүй, хуралд хувьцаа эзэмшигч Улаанбаатар импэкс ХХК-ийг төлөөлж итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Нурболат, Монголбанкны хянагч Б.Оргилсайхан нар ирсэн. Хурал хууль болон дүрэмд заасан ирц бүрдээгүй учир хуралдаагүй, 2022.04.20 өдрийн ТУЗ-ийн Т/22/15 тогтоолоор хойшлогдсон хурлыг 2022.04.29 өдөр зарлан хуралдуулсан.
2. 2022-04-29: Хойшлогдсон ээлжит хурлын даргаар томилогдсон, хуралд хувьцаа эзэмшигч Улаанбаатар импэкс ХХК-ийг төлөөлж хувьцаа эзэмшигч Ш.Баярсайхан оролцсоноор хурлын ирц 67.15% буюу хуульд заасан шаардлагыг хангасан учир хурлыг хүчин төгөлдөрт тооцон хуралдуулсан. Хуралд Монголбанкны хянагч Б.Оргилсайхан байлцсан. Хурлаар 4 асуудал хэлэлцүүлсэн:
 1. Хөндлөнгийн аудитын дүгнэлтийг танилцуулах,
 2. Ногдол ашиг хуваарилахгүй тогтоолыг танилцуулах
 3. Банкны 2021 оны санхүү, үйл ажиллагааны тайланд ТУЗХ-аас өгсөн дүгнэлтийг батлах
 4. ТУЗ-ийн 2022 оны төсвийг батлах

Банкны гүйцэтгэх удирдлагаас 2021 оны санхүүгийн дэлгэрэнгүй тайлан, үйл ажиллагааны тайланг танилцуулсан, мөн тайланд ТУЗ-ийн хурлаас өгсөн “хангалттай” гэсэн үнэлгээг болон ТУЗ-ийн ирэх оны төсвийг хэлэлцүүлснийг ХЭЭХ-д оролцсон хувьцаа эзэмшигч “Улаанбаатар импэкс” ХХК-ийн төлөөлөл хувьцаа эзэмшигч Ш.Баярсайхан дэмжсэн. Мөн ТУЗ-ийн 2022.03.16 –ны өдрийн Т/22/09 дугаартай тогтоолоор “Банкны 2021 оны санхүүгийн тайлангаар санхүүгийн зохистой харьцааг хангахгүй байгаа тул ногдол ашиг хуваарилахгүй” гэсэн тогтоолыг танилцуулсан. ТУЗ-ийн 2022.03.16 –ны өдрийн Т/22/08 дугаартай тогтоолоор “Банкны 2021-12-31-ний өдрөөр тасалбар болгон холбогдох хууль, стандартын дагуу тайлагнасан санхүүгийн тайланд “Хүлэгт хүннү аудит” ХХК-ийн аудит хийж гаргасан дүгнэлтийг танилцуулсан. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас Х/22/05 тогтоолоор “ТУЗ-ийн хурлаас гаргасан дүгнэлтийг батлах”, Х/22/06 дугаартай тогтоолоор “ТУЗ-ийн 2022 оны төсвийг батлах” тогтоолуудыг саналын эрхийн 67.15%-аар батлан гаргасан. Хурлыг хуульд заасны дагуу удирдан зохион байгуулсан.

3. 2022-04-28: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2022.04.20 өдрийн Т/22/16 тоот тогтоолоор зарлан хуралдуулсныг даргалсан. Хуралд хувьцаа эзэмшигч “Улаанбаатар импэкс” ХХК-ийг төлөөлж хувьцаа эзэмшигч Ш.Баярсайхан оролцсон, мөн хуралд Монголбанкны хянагч Б.Оргилсайхан, С.Мөнх-Эрдэнэ нар байлцсан. Уг хурлаар Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022.04.14-ний өдрийн Н/53 дугаартай “Хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх, бүтцийг өөрчлөх тухай” албан бичигт Ариг банк ХХК-ийн хувьцаа эзэмшигч Улаанбаатар импэкс ХХК-д банкны хувь нийлүүлсэн хөрөнгийг 10,583,282,950 төгрөгөөр нэмэгдүүлж банканд 71.78% эзэмших зөвшөөрлийг олгосны дагуу Ариг банк ХХК-ийн дүрмийн 4.3-т өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцүүлж Х/22/04 дугаартай ““Ариг банк” ХХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоолыг саналын эрхийн 67.15%-аар батлан гаргасан. Хурлыг хуульд заасны дагуу удирдан зохион байгуулсан.
4. 2022-05-05: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2022.04.26 өдрийн Т/22/19 тоот тогтоолоор зарлан хуралдуулсныг даргалсан. Уг хурлаар:
 - Дэм санхүүгийн нэгдэл ХХК-ийн татгалзсан хувьцааг нөгөө хувьцаа эзэмшигчид санал болгох,
 - МВАРМ ХХК-ийн хувьцааны талааргэсэн 2 асуудлыг хэлэлцүүлэхээр товлосон. Уг хуралд хувьцаа эзэмшигч “Улаанбаатар импэкс” ХХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал И.Галбуян итгэмжлэлээр, хувьцаа эзэмшигч “Дэм санхүүгийн нэгдэл” ХХК-ийг төлөөлж хувьцаа эзэмшигч Б.Эрдэнэбат нар оролцож хурлын ирц 100% хуралдсан. Хурлаар хэлэлцүүлсэн 1-р асуудал болох “Дэм санхүүгийн нэгдэл” ХХК-ийн татгалзсан хувьцааг нөгөө хувьцаа эзэмшигчид санал болгох” асуудлаар хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдээс санал хураахад:
 - 67.15%-ийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч Улаанбаатар импэкс ХХК зөвшөөрсөн,
 - 32.85%-ийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч Дэм санхүүгийн нэгдэл ХХК татгалзсангэсэн саналыг хураалгаж, хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 67.15%-ийн саналаар хэлэлцсэн асуудлыг зөвшөөрч шийдвэрлэн Х/22/07 дугаартай Хувьцаа худалдан авахыг санал болгох тухай” тогтоолыг гарган баталгаажуулсан. Хурлаар хэлэлцүүлсэн 2-р асуудал болох –“МВАРМ ХХК-ийн хувьцааны талаар” асуудлыг хэлэлцэхээс татгалзсанаар хурлыг дуусгасан. Хурлыг хуульд заасны дагуу удирдан зохион байгуулсан.
5. 2022-06-28: Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд заасан өөрчлөлтийг 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс дагаж мөрдөх болсонтой холбоотой “Ариг банк” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр зарлан хуралдуулсан. Хуралд хувьцаа эзэмшигч “Улаанбаатар импэкс” ХХК-ийн Гүйцэтгэх захирал И.Галбуян оролцсон. Хурлаар банкны дүрэмд нэмэлт, өөрчлөлтийг хуульд нийцүүлэн тусгаж Х/22/08 дугаартай тогтоолын хавсралтаар саналын эрхийн 67.15%-аар батласан юм. Батлагдсан дүрмийг хянан шалгуулахаар Монголбанкны эрх зүйн газарт хүргүүлсэн. Хурлыг хуульд заасны дагуу удирдан зохион байгуулсан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал даргалсан, оролцсон байдлын тайлан:

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 4 дүгээр сард 2, 5 дугаар сард 2, 6 дугаар сард 2 удаа нийт 6 удаа хуралдсан.

2022 оны 4 дүгээр сард оролцсон ТУЗ хурлууд:

1. 2022-04-20-ны өдөр хуралдсан ТУЗ хурлыг даргалсан. Хурлын ирц бүрэн, ТУЗ гишүүд бүгд оролцсон. Хурлаар 2 асуудлыг хэлэлцсэн.
 - Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хойшлуулан товлох (2022-04-20 өдөр хуралдсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал ирц хүрээгүй улмаас КТХ-д зааснаар хойшлогдсон хурлыг зарласан),
 - хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын товыг зарлах (Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022.04.14-ний өдрийн Н/53 дугаартай “Хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх, бүтцийг

өөрчлөх тухай” албан бичиг ирсэн учир банкны хувь нийлүүлсэн хөрөнгөнд өөрчлөлт оруулсан дүрмийг батлан хэлэлцэх асуудлыг хэлэлцэх)

хойшлогдсон хурлыг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр хуралдуулахаар товлосон Т/22/15 дугаартай тогтоол, ээлжит бус хурлыг 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр хуралдуулахаар товлосон Т/22/16 дугаартай тогтоолыг хурлаас батлан гаргасан. Гишүүдээс санал зөрсөн, хуралд оролцоогүй асуудал гараагүй. Хараат бус гишүүн миний хувьд хэлэлцсэн 2 асуудлыг дэмжсэн саналтайгаар оролцсон.

2. 2022-04-26-ны өдөр хуралдсан ТУЗ хурлыг даргалсан. Хурлын ирц бүрэн, ТУЗ гишүүд бүгд оролцсон. Хурлаар 4 асуудлыг хэлэлцсэн.

1. Хувьцаа эзэмшигч Улаанбаатар импэкс ХХК-аас ирүүлсэн хувьцаа худалдан авах саналыг хүлээн авах, гэрээнд гарын үсэг зурах эрх олгох
2. Хувьцаа эзэмшигч Дэм санхүүгийн нэгдэл ХХК-аас хувьцаа худалдан авах саналыг ирүүлээгүй тул татгалзсанд тооцох,
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын товыг зарлах, хэлэлцэх асуудлыг батлах
4. Корреспондент банкт хамтарч ажиллах, гүйцэтгэх удирдлагад эрх олгох тухай

Хэлэлцүүлсэн 1-р асуудлын тухайд: Хуралд оролцсон гишүүдийн 100%-ийн саналаар: “Ариг банк” ХХК-иас эргэлтэнд гаргаж байгаа нэг бүр нь 21,166,565.90 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 681 ширхэг энгийн хувьцааг хувьцаа эзэмшигч “Улаанбаатар импэкс” ХХК худалдан авах саналаар ирүүлсэн тул хувьцаа эзэмшигчийн санал, баримт бичгийг шалгуулах, зохих зөвшөөрлийг авахаар Монголбанкинд хүргүүлэх, хувьцаа эзэмшигч “Улаанбаатар импэкс” ХХК-тай “Хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэр байршуулах гэрээ”-г байгуулах, уг гэрээнд “Ариг банк” ХХК-ийг төлөөлөн гарын үсэг зурах эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад олгох Т/22/17 тогтоолыг, Хэлэлцүүлсэн 2-р асуудлын тухайд: Хуралд оролцсон гишүүдийн 100%-ийн саналаар “ТУЗ тогтоолд заасан хугацаанд санал, баримт бичгээ ирүүлээгүй тул хувьцаа эзэмшигч “Дэм санхүүгийн нэгдэл” ХХК-ийг санал болгосон энгийн хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэхээс татгалзсанд тооцох, “Дэм санхүүгийн нэгдэл” ХХК-д санал болгосон 500 ширхэг энгийн хувьцааг хууль тогтоомжид заасны дагуу бусад хувьцаа эзэмшигчид санал болгох асуудлыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх, энэ талаар хувьцаа эзэмшигч “Дэм санхүүгийн нэгдэл” ХХК-д мэдэгдэх Т/22/18 тогтоолыг,

Хэлэлцүүлсэн 3-р асуудлын тухайд: Хуралд оролцсон гишүүдийн 100% саналаар 2022 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 10 цагаас хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг “Ариг банк”-ны төв байранд зарлан хуралдуулах, хурлаар “Дэм санхүүгийн нэгдэл” ХХК-ийн татгалзсан хувьцааг нөгөө хувьцаа эзэмшигчид санал болгох, МВАРМ ХХК-ийн хувьцааг худалдах эсэх тухай асуудлыг хэлэлцэхээр батласан тогтоолыг,

Хэлэлцүүлсэн 4-р асуудлын тухайд: Хуралд оролцсон гишүүдийн 100% саналаар гүйцэтгэх удирдлагад ОХУ-ын сонгосон банкт хамтарч ажиллах зохих зөвшөөрлийг тогтоолоор олгох, гадаадын банкт ажиллахдаа зохих эрсдэлийг хааж сайтар нягтлан хамтарч ажиллах гэрээг хийхийг зөвшөөрсөн тогтоолыг тус тус батлан шийдвэрлэсэн. Гишүүдээс санал зөрсөн, хуралд оролцоогүй асуудал гараагүй. Хараат бус гишүүн миний хувьд хэлэлцсэн 4 асуудлыг дэмжсэн саналтайгаар оролцсон.

3. 2022-05-13: ТУЗ хурлыг даргалсан. Хурлын ирц бүрэн, ТУЗ гишүүд бүгд оролцсон Хурлаар дараах асуудлыг хэлэлцсэн.

1. Сервер компьютер, сторэйж болон сүлжээний төхөөрөмжүүдийн нийлүүлэгчийг сонгох шалгаруулах талаар танилцуулах
2. ӨБХ-ийн үнэ тогтоох, худалдан борлуулах зөвшөөрөл олгох

Хэлэлцүүлсэн 1-р асуудлын тухайд: Банкнаас нээлттэйгээр зарласан "Сервер компьютер, сторэйж, сүлжээний төхөөрөмж нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер"-ийн хугацааг 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл сунган, хаалттайгаар зарлах Т/22/21 тогтоолыг,

Хэлэлцүүлсэн 2-р асуудлын тухайд: Өмчлөх бусад хөрөнгөд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийн үнийг тогтоох, худалдан борлуулах зөвшөөрөл олгох тухай Т/22/22 тогтоолын хавсралтаар нийт банкны өр авлагад хураагдаж, өмчлөх хөрөнгөд бүртгэгдсэн 33 үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах үнийг тогтоох, худалдах зөвшөөрлийг олгосон юм.

Хэлэлцүүлсэн асуудлуудыг дэмжиж санал өгсөн.

4. 2022-05-24: ТУЗ хурлыг даргалсан. Хурлын ирц бүрэн, ТУЗ гишүүд бүгд оролцсон. Хурлаар 3 асуудлыг хэлэлцсэн.

1. Хувьцаа эзэмшигч Улаанбаатар импэкс ХХК-аас ирүүлсэн хувьцаа худалдан авах саналыг хүлээн авах, гэрээнд гарын үсэг зурах эрх олгох

2. Бүтэц, орон тооны өөрчлөлт хийх зөвшөөрөл олгох

3. Ариг банкны 40 мянгат салбарын түрээсийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх

Хэлэлцүүлсэн 1-р асуудлын тухайд: Хуралд оролцсон гишүүдийн 100% саналаар "Ариг банк" ХХК-иас эргэлтэнд гаргаж, санал болгосон нэг бүр нь 21,166,565.90 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 500 ширхэг энгийн хувьцааг хувьцаа эзэмшигч "Улаанбаатар импэкс" ХХК худалдан авах саналаа хуульд заасан шаардлагыг хангаж ирүүлсэн тул хувьцаа эзэмшигчийн санал, холбогдох баримт бичгийг шалгуулах, зохих зөвшөөрлийг авахаар Монголбанкинд хүргүүлэх, 500 ширхэг хувьцааны үнэ 10,583,282,950 (арван тэрбум таван зуун наян гурван сая хоёр зуун наян хоёр мянга есөн зуун тавь) төгрөгийг Ариг банкны дансанд байршуулсан тул хувьцаа эзэмшигч "Улаанбаатар импэкс" ХХК-тай "Хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэр байршуулах гэрээ"-г байгуулах, уг гэрээнд "Ариг банк" ХХК-ийг төлөөлөн гарын үсэг зурах эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга П.Мөнх-Эрдэнэ надад олгосон Т/22/23 тогтоол гарсан тул гэрээнд гарын үсэг зурсан.

Хэлэлцүүлсэн 2-р асуудлын тухайд ТУЗ-ийн 2021 оны Т/49 тоот тогтоолоор батлагдсан Ариг банкны бүтэц, зохион байгуулалт, орон тоог нэмэгдүүлэхгүй, нэмэлт зардал гаргахгүйгээр банкны ажлын ачааллыг тэнцвэржүүлэх үүднээс зарим албан тушаалыг газар хэлтэс дотроо шилжүүлэх зэргээр тогтоолын хавсралтад зарим нэг өөрчлөлт оруулах эрхийг Гүйцэтгэх захиралд олгосон Т/22/24 тоот тогтоол гарган баталгаажуулсан.

Хэлэлцүүлсэн 3-р асуудлын тухайд: ЧД-1, Дөчинмянгат 7-р байрны 1 дүгээр давхар хаягт байрлах иргэн Д.Сэргэлэнгийн 361 м.кв талбай бүхий үйлчилгээний зориулалттай байрыг "Ариг банк" ХХК-ийн тооцооны төв ажиллуулах зорилгоор 1м.кв талбайг 63000 төгрөгөөр, нийт 361 м.кв талбайг сарын 22,743,000 /хорин хоёр сая долоон зуун дөчин гурван мянга/ төгрөгөөр 3 жилийн хугацаатайгаар түрээслэхийг зөвшөөрсөн Т/22/25 тоот тогтоол гарган баталгаажуулсан.

Дээрх хэлэлцэх асуудлуудад дэмжсэн саналтайгаар оролцсон.

5. 2022-06-15: ТУЗ хурлыг даргалсан. Хурлыг цахимаар хуралдсан, ирц бүрэн. Монголбанкны 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А-19/560 тоот албан бичгээр "Ариг банк"-наас батлан хүргүүлсэн "Тогтворжуулах төлөвлөгөө"-г дахин шинэчлэн батлан ирүүлэх үүрэг өгсний дагуу төлөвлөгөөний шинэчилсэн хувилбарыг дахин хэлэлцэн албан бичигт заагдсан хугацаанд Т/22/26 тоот тогтоолоор батлан хүргүүлсэн.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дээрх хурлуудад хараат бус гишүүний хувьд бусад гишүүдтэй зарчмын зөрүүтэй байр суурь илэрхийлэгдээгүй болно. Мөн эдгээр хурлуудын хэлэлцэх асуудалд ашиг сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл батлах асуудал ороогүй болохыг дашрамд дурдаж байна.

Тайлан бичсэн: ТУЗ-ийн дарга,

хараат бус гишүүн П.Мөнх-Эрдэнэ

